



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

***2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН, СТАТИСТИК МЭДЭЭ***





Гарчиг

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл

Хоёрдугаар бүлэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Гуравдугаар бүлэг. Санхүүгийн аудитын талаар

Дөрөвдүгээр бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар

Тавдугаар бүлэг. Нийцлийн аудитын талаар

Зургаадугаар бүлэг. Өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

Долоодугаар бүлэг. Байгууллагын дотоод ажлын талаар

Наймдугаар бүлэг. Дүгнэлт, санал



НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Тайлант он Улсын Их Хурлын болон Орон нутгийн ИТХ-ын сонгууль зохион байгуулагдсан онцлог жил байлаа.

Архангай аймгийн Аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнөөр дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2016 оны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг 39 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон ажиллалаа.

Аудитын газар нь www.audit.mn веб сайтаар 2016 онд хийсэн бүх аудитын тайлан, дүгнэлтийг байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Аудитын газрын 2016 оны үндсэн гол үйл ажиллагааг хугацаагаар тоймлон харуулбал:

Нэгдүгээр сард:

- Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит эхэлж байгаатай холбогдуулан аймгийн санхүү төрийн сангийн хэлстийн дарга, ерөнхий нягтлан бодогч нартай аудитад анхаарах асуудлын талаар ярилцлага зохион байгуулав.
- 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу улс, орон нутгийн төсвийн шууд, захирагчдийн 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийв.

Хоёрдугаар сард:

- Аймгийн аудитын газрын 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг баталж, аудит бүрт шаардагдах нөөцийг хуваарилж, аудитор, шинжээч нартай үр дүнгийн гэрээ байгуулан, аудитыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг хангав.
- Аудитын газар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж багийн зохион байгуулалтад шилжив.
- Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэгт заасны дагуу Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоов.



Гуравдугаар сард:

- Архангай аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу улс, орон нутгийн төсвийн шууд захирагчдийн санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт өгч баталгаажуулав.
- ҮАГ-ын харьяа Архангай аймгийн Аудитын газар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудит, “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, үр дүн”-д хийх нийцлийн аудитуудын нээлтийг хийж аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг танилцууллаа. Нээлтэнд аймгийн тамгын газрын дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Хөгжлийн бодлогын мэргэжилтэн болон СТСХ-ийн нягтлан бодогч нар оролцов.

Дөрөвдүгээр сар

- Архангай аймгийн Аудитын газар сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргав.
- Төсвийн тухай хуульд заасан цаглабарын хугацаанд СТАУС программаар Орон нутгийн ТЭЗ-ийн 2015 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж аудитын дүгнэлт, тайланг ҮАГ болон аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Тавдугаар сар

- Архангай аймгийн Аудитын газар “Шилэн дансны хуулийн хэрэгжилт”, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудит, “Орон нутгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулж ҮАГ болон Аймгийн засаг даргад хүргүүлж цахим сайтад байршуулав.

Зургаадугаар сар.

- Үндэсний Аудитын газраас зохион байгуулсан АДБОУС-ын сургалтанд хамрагдав.
- Эхний 5 сарын байдлаар хийгдсэн аудитын дүнгийн талаар аудитор, шинжээчдийн дунд хоёр шаттай шүүмж, ярилцлага зохион байгуулав.
- ҮАГ-ын харьяа Архангай аймгийн аудитын газраас **“Нягтлан бодогчдийн мэргэжлийн ур чадвар, аудитын дүнд нөлөөлөх нь”** сэдэвт хэлэлцүүлгийг аймгийнхаа Мэргэшсэн нягтлан бодогч нарын дунд зохион байгуулж нийт төсөв захирагч, нягтлан бодогч нарт хандан Уриалга гаргав.



Долоодугаар сар.

- Архангай аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Сумдын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоов.

Наймдугаар сар

- “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн хэрэгжилтэнд хийх нийцлийн аудитын нээлтэнд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, БОГ-ын дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Татварын албаны дарга, СТСХ-ын дарга нар оролцов.
- Архангай аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Орон нутгийн өмчийн эд, хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтын үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Өмчийн албаны төлөөлөгч нарт танилцуулж, төгсгөлийн уулзалт хийв.

Есдүгээр сар

- Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийх нийцлийн аудитын нээлтэнд аймгийн ЗДТГ-ын Хүн ам хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөрийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Архангай, Гурвантамир, Булган, Дэд бүтэц МСҮТ-ийн захирал, холбогдох албан тушаалтнууд оролцов.

Аравдугаар сар

- Архангай аймгийн Аудитын газар ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”, “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлэв.
- Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг холбогдох МСҮТ-дийн захирал, нягтлан бодогч, сургалтын менежер нарт танилцуулж аудитын төгсгөлийн уулзалт хийв.
- Аудитын акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангах үүднээс аймгийн Прокурорт хандав.



Арваннэгдүгээр сар

- УАГ-ын харьяа Архангай Аймгийн Аудитын газар 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016 оны эхний 3-р улирлын хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит, Шилэн дансны аудитуудын нээлт хийв.
- Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн хандивын жагсаалтыг зарлав.
- 2016 оны Мэргэжлийн тасралтгүй сургалтын хаалт хийв.
- Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу өөрийн төлөвлөгөөгөөр “Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, БОАЖГ-т тус тус хүргүүлэв.
- Аудитын газрын үндсэн үйл ажиллагааны ажлыг эрчимжүүлэх үүднээс 2016.11.15-2016.12.15-ныг хүртэл “Бүтээлч сарын аян”-ыг Санхүү, Гүйцэтгэл, Нийцлийн аудитын багуудын дунд зохион байгуулж, ажлын төлөвлөгөө батлав.
- Засгийн газрын тусгай сан, Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит, Ойжуулалтад зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аудитор шинжээчид танилцуулж, Удирдлагын зөвлөлд тайлан хамгаалах ажлыг зохион байгуулав.

Арванхоёрдугаар сар.

- Архангай аймгийн Аудитын газрын 2016 оны Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тайланг хүргүүлэв.
- Төсвийн төсөлд санал хүргүүлэв.
- Бүтээлч сарын аяныг дүгнэв.



ХОЁР . УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Архангай аймгийн Аудитын газар 2016 онд Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

- ❖ Аудитын газар 12 орон тоотойгоор 22704 хүн/цаг ажиллаж ажлын цаг ашиглалт 100%-тай байлаа. Нийт дүнгээр 1024 хүн/цаг илүү ажилласан байна.
- ❖ Монгол Улсын Ерөнхий аудитортой байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт 97.4 % буюу 39 төрлийн ажил гүйцэтгэхээс 38 төрлийн ажлыг гүйцэтгээд байна.
- ❖ Үндсэн үйл ажиллагааны хувьд гүйцэтгэлийн 7, санхүүгийн тайлангийн аудит 113, нийцлийн 6, завсарын аудит нийтдээ 126 аудит хийлээ. Үүнээс 1 аудит одоо хийгдэж байгаа бөгөөд үндсэн ажлын гүйцэтгэл 99.2%-тай байна.
- ❖ Аудитаар нийт 7,963.1 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 7235.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж, төлбөрийн актаар 51.2 сая төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.
- ❖ Нийт 7054.2 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, биелэлт 98.9% -тай байна.
- ❖ Нийт 146 зөвлөмж хүргүүлсэний 39 нь арвилан хэмнэлт, үр ашигтай холбоотой, 18 нь НББ, тайлагналтай, 46 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 27 нь дотоод хяналттай, 16 нь бусад асуудлуудтай холбоотой бөгөөд биелэлт 86.9%-тай байна.
- ❖ Аудитын газар 2016 онд багаар ажиллахаар шийдсэн ба 2016 оны 2 сарын 25-наас багийн зохион байгуулалтад орж Санхүүгийн аудитын баг 4 хүнтэй, Гүйцэтгэлийн аудит, Нийцлийн аудитын багууд тус бүр 2 хүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Багийн зохион байгуулалтаар ажилласнаар хүрэх үр дүн нь:

- ҮАГ-ын төрөлжсөн газруудтайгаа шууд холбогдоно.
- Ажлыг аудитын багаар дүгнэх боломж бий болно.
- Тодорхой ажлын чиглэлтэй байх нь тухайн аудитад илүү үр дүн авчирна.
- Багуудын хооронд өрсөлдөөн бий болж ажлын чанар сайжирч, аудитор, шинжээчдийн идэвх оролцоо нэмэгдэнэ.
- Баг бүр өөр өөрийн аудитын тайланг шилдэг тайланд хүрэх хэмжээнд бичих , хийх шаардлагыг тавьж өгсөн.



- ❖ Аудитын үйл ажиллагаанд хууль тогтоомж, эрх зүйн актуудыг хэрэглэх, ойлгоход зөвлөгөө авах зорилгоор аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн гишүүн хуульчтай хууль зүйн туслалцаа авах гэрээ байгуулан ажиллалаа.
- ❖ Аудитын газар 2016 онд төлөвлөгөөт ажлуудаас гадна аудитор, шинжээчдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарч, ажлын байран дахь сургалтыг үр дүнтэй явуулсаны дүнд давхардсан тоогоор 180 хүн сургалтанд хамрагдаад байна.
- ❖ 2016 онд нийт 6.5 сая төгрөгийг урамшуулал, илүү цагийн хөлсөнд олгосны 3.6 сая төгрөгийг эхний хагас жилийн ажлын үр дүнгээр, 2.9 сая төгрөгийг илүү цагийн хөлсөнд тус тус олголоо.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Аймгийн аудитын газар Санхүүгийн тайлангийн аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторовын 2015 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/249-р тушаал, Тэргүүлэх аудиторовын 2015 оны 11 дүгээр сарын 11-ний А/25-р тушаал болон МУЕА-ын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-д заасан арга зүйн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитад “СТАУС” программ хангамжийг бүрэн ашиглаж, давхардсан тоогоор 20 хүн ажиллаж, 98 өдөр зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт **218** улс, орон нутгийн төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын төсөв захирагчдын тайланд аудит хийхээс **113** төсөв захирагчдын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгч, **28** санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, **77** тайланг түүвэрт хамруулсан.

Санал дүгнэлт өгсөн санхүүгийн тайлангуудын **97.3** хувь буюу **110** санхүүгийн тайланг өөрийн хүчээр, **7** хувь буюу **3** санхүүгийн тайланг хувийн аудитын компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.

Санал дүгнэлт өгсөн **113** санхүүгийн тайлангийн **85.8** хувь буюу **97** тайланд **Зөрчилгүй**, **13.3** хувь буюу **15** тайланд **Хязгаарлалттай** санал дүгнэлт өгч, **0.9** хувь буюу **1** тайланд **дүгнэлт өгөхөөс татгалзлаа**.

Хязгаарлалттай болон татгалзсан дүгнэлт авсан байгууллагуудын нийт 16 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28.1 дэхь заалтын дагуу хариуцлага тооцуулах санал бүхий албан шаардлагыг хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **6,013.3** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад **514.6** сая төгрөгийн алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, **251.1** сая төгрөгийн алдаа зөрчлийг засаж залруулах, анхааран ажиллах зөвлөмжийг менежментийн захидлаар өгч, **5,211.1** сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх албан шаардлага хүргүүлэн **99.6** %-ийн биелэлтийг хангуулж, **35.8** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож **99.2**%-ийг барагдуулж, орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээ.

Нийт алдаа зөрчлийн 87.3%-ийг НББ, тайлагналтай холбоотой, хөрөнгийн тооллого хийгээгүй, малын нас дэвшилтийг бүртгээгүй гэх мэт 5,249.5 сая төгрөгийн зөрчил эзэлж байна.

Аудитаар нийт **93** зөвлөмж өгөгдсөний 34.4% нь арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 21.5% нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 17.2% нь бусад чиглэлээр, 16.1% нь бүртгэл тайлагналтай холбоотой, 10.8% нь дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгөгдсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 100%-тай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаас дараах үр өгөөжийг бий болгон ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар **5326.1** сая төгрөгийн үр өгөөжийг бий болгосон. Үүнээс орон нутгийн төсөвт 35.7 сая төгрөг төвлөрүүлсэн, Эрдэнэмандал сумын ИТХ, ЗДТГ, Ихтамир сумын ЭМТ, Хотонт сумын Хүүхдийн цэцэрлэг жилийн эцсийн тайлангаар 3,755.0 сая төгрөгийн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй, 20.0 сая төгрөгийн хөрөнгийг өмчийн албаны зөвшөөрөлгүй бэлтгэсэн байсныг албан шаардлага өгч зөрчлийг арилгуулан тооллогыг хийлгүүлэн бүртгэл тайланд тусгуулсанаар өмч хөрөнгийг хадгалалт хамгаалалттай болгож, хөрөнгө эзэнгүйдэх, эвдэрч гэмтэх улмаар хөрөнгийн зарцуулалтыг үр дүнгүй болгох эрсдэлээс сэргийлж чадсан үр өгөөжийг бий болголоо.

2016 оны тухайд улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдал, төсвийн хэмнэлтийн горимд шилжсэн, тэвчиж болох зардлыг гаргахгүй байх шаардлага тавигдаж байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэхээс татгалзаж аль болох өөрсдийн хүчээр хийх, завсрын аудитын хамрах хүрээг өргөтгөх, 3-с доошгүй гэрээт ажилтан ажиллуулах зэргээр шийдвэрлэсэн болно.



Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар:

Монгол Улсын Ерөнхий Аудиторт нийлүүлэх аймгийн Аудитын газрын 2016 оны жилийн ажлын төлөвлөгөө, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө удирдамж, чиглэлийн дагуу нийт 1 их наяд 277 тэрбум 931.4 сая төгрөгийн санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан 6 аудитыг хийж, аудитад давхардсан тоогоор 10 хүн оролцож, 196 өдөр зарцуулан ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитаар бий болсон үр өгөөжийн талаар:

Гүйцэтгэлийн нийт **1218.4** сая төгрөгийн зөрчил илэрснээс 1120.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 албан шаардлага, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, арвилан хэмнэх, дотоод хяналтыг сайжруулахад чиглэсэн 29 зөвлөмжийг холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлсэн байна. Мөн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 98.2 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж, цаашид хэрэгжүүлбэл зохих асуудлын талаархи 3-н саналыг ҮАГ-т уламжилж ажиллалаа.

Тайлангийн хугацааны эцэст өөрийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн үр дүнгийн аудитаас өгөгдсөн 92.0 сая төгрөгийн албан шаардлага, 15 зөвлөмжийн хэрэгжилт он дамжин дараа онд биелэлт хангагдахаар байгаа бөгөөд бусад аудитаас өгсөн **1113.9** сая төгрөгийн 9 албан шаардлага, 14 зөвлөмжийн биелэлтийг 100% хангуулж аудитын үр өгөөжийг бий болголоо. Үүнд:

- ✚ Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн аймгийн төвийн 11-р цэцэрлэгийн байр, Эрдэнэбулган сумын 6-р багийн бага сургуулийн барилгын их засварын ажлуудыг тайланд **22.2** сая төгрөгөөр дутуу бүртгэснийг бүрэн бүртгүүлэх арга хэмжээ авсан.
- ✚ Эрдэнэбулган сумын эрчим хороололын цэвэр бохир усны гол магистрал шугам 76 айлын салбар шугам сүлжээний ажилд олгосон **220.0** сая төгрөгийн дуусаагүй ажлыг бүртгээгүй зөрчлийг арилгуулсан.
- ✚ Аймгийн төвийн цахилгаан хангамжийг сайжруулах **485.1** сая төгрөгийн ажлыг улсын комисс хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй байсан зэрэгт албан шаардлага өгч бүртгэлд тусгуулснаар өмч хөрөнгийг хадгалалт хамгаалалттай болгож, хөрөнгө эзэнгүйдэх, эвдэрч гэмтэх улмаар хөрөнгийн зарцуулалтыг үр дүнгүй болох эрсдэлээс сэргийлж чадсан үр өгөөжийг бий болголоо.
- ✚ Мөн ХАА-г төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт багтаан зохион байгуулалгүй **57.3** сая төгрөгөөр хэтрүүлсэн нь эх үүсвэр дутагдах эрсдлийг бий болгосон төдийгүй хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй,



мөрддөггүй уламжлагдаж ирсэн дутагдлыг албан шаардлага хүргүүлж, таслан зогсоож чадсан.

- ✚ Улсын нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хийсэн аудитаар Улсын нөөцийн агуулахад **27.4** сая төгрөгийн 2535 боодол ОХУ-д үйлдвэрлэгдсэн тэжээл хадгалагдаж байсан ба хадгалалтын хугацаа дуусаад 2 сар өнгөрсөн байсан нь ОБЕГ-ын Улсын нөөцийн газрын даргын 8/125 тоот “2015 онд хэрэгжүүлж ажиллах үүрэг, даалгавар”-ын 2 дахь хэсэгт *“Нөөцийн бараа, материалын хадгалалтын хүчинтэй хугацаа дуусахаас 3 сарын өмнө Улсын нөөцийн газарт албан бичгээр урьдчилан мэдэгдэж шинэчлэх асуудлыг шийдвэрлүүлж байх”* гэсэн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж ажиллаагүй байсан зөрчлийг албан шаардлага өгч таслан зогсоосон болно.
- ✚ Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийсэн аудитаар ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нартай холбоотой 155.0 сая төгрөгийн ойжуулалтын нөхөн тарилт, хамгаалалт, хаяг, тэмдэгжүүлэлт хийлгэх, 44.9 сая төгрөгийн ногоон байгууламжинд мод тарих ажлыг гүйцэтгүүлж хүлээн авч нотлох баримтыг ирүүлэх албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т, аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүн, үр нөлөөг тооцох, ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай 11 зөвлөмжийг аймгийн Засаг дарга, аймгийн БОАЖГ-т тус тус хүргүүлэн хэрэгжилтийг хангуулаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, Улсын нөөцийн бүрдүүлэлт хуваарилалт, зарцуулалтын байдалд хийсэн аудитуудаас дараах хөрөнгө оруулалтын ажлыг ҮАГ-аар дамжуулан СЯ болон БСШУЯ-д уламжилж ажиллалаа.

1. 2011 оноос хойш Аймгийн Номын сангийн барилгын ажлыг “Донж хацуу” ХХК гүйцэтгэж байгаа боловч өнөөг хүртэл ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй, уг барилга чанар муутай баригдсанаас ашиглалтанд ороогүй байхад гадна фасад нурсан, ханын шавар хагарсан байдалтай байна. Уг барилгын асуудлыг шийдвэрлүүлэхээр БШУЯ болон холбогдох газруудад удаа дараа хандсан боловч тодорхой арга хэмжээ авахгүй байсаар байгаа төдийгүй орон нутагт улсын төсвийн 486.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт үр дүнгүй “балгас” болон үлдэхэд хүрч байгаа тул анхаарал хандуулах шаардлагатай байна.
2. Улсын нөөцийн салбарт ирсэн Өвсний хэвийн хорогдлыг тооцохдоо БНМАУ-ын Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн нэгдлийн даргын 1989 оны 5 сарын 03-ны өдрийн 48 тоот тушаалын хавсралтаар баталсан “Өвсний хэвийн хорогдлын нормыг ашиглах заавар”-ын хавсралт



таблицыг мөрдөж байгаа нь нөөцийн өвсийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах эрсдэл үүсгэхээр байна. Иймд хорогдол тооцох журмыг орчин үеийн барилга, байгууламж, агуулахын нөхцөл байдалд үндэслэн шинэчлэн боловсруулах

3. Архангай аймгийн Төвшрүүлэх суман дахь Улсын нөөцийн салбарт 2016 оны 05 сарын 03-ны өдрийн байдлаар хугацаа дууссан байж болох хивэгний үлдэгдэл байгаад МХЕГ-ын дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг ОБЕГ-т уламжлах саналыг хүргүүлж ажиллалаа.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Аймгийн Аудитын газар 2016 онд Монгол улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооноос баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны төлөвлөгөөний дагуу Нийцлийн аудитын газрын төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд нийцлийн 6 аудит хийхээс 5 аудитыг бүрэн хийж дуусгасан, одоогоор 1 аудит үргэлжилж байна. Нийцлийн аудитаар нийт 617 байгууллага, аж ахуйн нэгжийн 28 тэрбум 471 сая 800 мянган төгрөгийн санхүүгийн хүрээ хамрагдсан бөгөөд аудитад 15 хүн оролцож, нийт 205 өдөр зарцуулсан байна. Аудитаар нийт **731.5** сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс **722.9** сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах 24 албан шаардлага өгч, **8.6** сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож нийт 11.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, 4.7 сая төгрөгийн төлбөрийн актыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Нийцлийн аудитаар бий болсон үр өгөөжийн талаар:

Нийцлийн аудитаар нийт **722.9** сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлснээс 93%-ийн биелэлттэй байна.

Нийцлийн аудитаар бий болсон үр өгөөжийн талаар:

Нийцлийн аудитаар **683.9** сая төгрөгийн үр өгөөж бүртгэгдсэний өмнөх оны 7.9 сая төгрөг, тайлант оны 676.0 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна. Үүнээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмнөх онд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй буюу дутуу олгогдсон **164.2** сая төгрөгийг дараа оны ОНХСангийн төлөвлөгөөнд тусгаж хөрөнгийн эх үүсвэрийг батлуулсан, **240.8** сая төгрөгийн төсөл арга хэмжээ дутуу буюу чанаргүй хийгдснийг дахин засварлан хийлгэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний



дүнд бий болсон **103.7** сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 ажлыг бүртгэл тайланд тусгуулснаар өмч хөрөнгийг хадгалалт хамгаалалттай болгож, хөрөнгө эзэнгүйдэх, эвдэрч гэмтэх улмаар хөрөнгийн зарцуулалтыг үр дүнгүй болгох эрсдэлээс сэргийлж чадсан бол байгаль орчныг хамгаалах тухай хэрэгжилтэнд хийсэн аудитаар **49.5** сая төгрөгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулах, ногоон байгууламжийн ажлыг нөхөн хийлгэж чадсанаар аудитын дүнд үр өгөөжийг бий болголоо.

Нийцлийн аудитаас ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах журам зааварт өөрчлөлт оруулж, тусгах шаардлагатай 2 саналыг ҮАГ-т уламжилж ажиллалаа. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний **урсгал зардалд** сангийн хөрөнгийн тодорхой хувийг зарцуулж болох зохицуулалт хэрэгтэй байна.

Учир нь: Тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалтын зардал тухайн ондоо шийдэгдэж, батлагдаагүй байдгаас уг ТАХ хэвийн ажиллах, ашиглагдах, үр ашгаа өгөх нөхцөл бүрдэхгүй байх, хугацаа алдах улмаар хөрөнгийн зарцуулалт үр дүн муутай болоход хүргэж байна.

2. Цаашид төсвийн зарцуулалтын **үр дүн** талаас авч үзвэл ОНХС-ийн хөрөнгийг орон нутагт шаардлагатай нийгмийн салбаруудад бодитой хөрөнгө оруулалт болгон төвлөрүүлэн зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь үр дүнтэй байхаар байна.

Товчхон: өнгөрсөн 3 жилийн хугацаанд аймагт зарцуулагдсан нийт хөрөнгийн 57.4% орчим нь барилга байгууламж, тоног төхөөрөмжид зарцуулагдаж хөрөнгө болжээ. Үүний дүнд тухайн сум орон нутагт тодорхой хэмжээнд бүтээн байгуулалт бий болсон. Харин үлдсэн 42.6% буюу 8.8 тэрбум орчим төгрөг нь урсгал шинжтэй засвар, жижиг хөтөлбөр арга хэмжээнд зарцуулагджээ.

Өөрөөр хэлбэл үлдэц багатай, цаг зуурын шинжтэй урсгал зардалд үр дүн багатай зарцуулагдсан байна гэж үзэхээр байгаа юм.

*Орон нутгийн ээлжит сонгуультай холбогдуулан
дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.*

- Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 41.3-т заасны дагуу аймаг, сумын орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг хуулийн хугацаанд тус тус тогтоож, шийдвэрийг аймгийн ИТХ-д хүргүүлж ажилласан.
- Мөн аймгийн ИТХ-ийн ээлжит сонгуульд оролцох 6 улс төрийн нам үүнд: АН, МАН, МАХН, ИЗНН, ХҮН, Монгол Үндэсний ардчилсан нам



мөн 4 бие даагчдын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хүлээн авч, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.1.17 ” Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана” гэж заасны дагуу хянан үзэж улс төрийн 5 нам, 4-н бие даагчдын мөрийн хөтөлбөрт “нийцсэн” дүгнэлт, 1 намын мөрийн хөтөлбөрт “нийцээгүй” гэсэн дүгнэлт гаргалаа.

- Сумын ИТХ-ын сонгуультай холбогдуулан Аудитын газарт улс төрийн 2 намаас тус бүр 19-н сумын намуудын нийт 38, 3-н бие даан нэр дэвшигчид бүгд 41 сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хүлээн авч, хянаж, дүгнэлтийг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Аудитын явцад мөрийн хөтөлбөртэй холбоотой зарим зүйлийг тодруулах үүднээс холбогдох улс төрийн намууд болон бие даагч нартай уулзаж, мөрийн хөтөлбөрийн зарим нэг заалтыг хуульд нийцүүлэх, эдийн засгийн тооцоолол, төсөөллийг бодиттой төлөвлөх талаар арга зүйн зөвлөгөө өгч, мөрийн хөтөлбөрийг засварлуулан шалгууртай нийцүүлэх арга хэмжээ авч ажиллалаа.

- Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 3 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулиар олгосон Үндэсний Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон улс

төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх аудитыг хийлээ.

Архангай аймгийн ИТХ-ын 19 сумын 25 тойрогийн 39 мандаттай сонгуульд МАН болон АН-аас тус бүр 39-н нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч -1 нийт 2 нам, 79 нэр дэвшигч оролцсон.

Аймгийн сонгуулийн хорооноос 2016 оны 8 сарын 11-ны өдрийн 105 тоот албан бичгээр 72 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг холбогдох баримтын хамт, аймгийн МАН зардлын тайлангаа хянуулахаар тус тус ирүүлснийг Сонгуулийн тухай хуулийн дагуу хянаж дүнг хуулийн хугацаанаас өмнө нийтэд мэдээлж ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийн дансанд 175 иргэнээс мөнгөн ба мөнгөн бус хандив 371165.6 мянган төгрөг, 7-н хуулийн этгээдийн хандив 64000.0 мянган төгрөг, 48 нэр дэвшигчдийн 72256.0 мянган төгрөгийн өөрийн хөрөнгө нийт 507427.6



мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрч, 481505.8 мянган төгрөг зарцуулагдсан байна.

Тав. Өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

2016 онд өөрийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэлийн 3, нийцлийн 1 аудит хийхээр төлөвлөгдснөөс газрын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийх нийцлийн аудит одоо үргэлжилж байгаа бөгөөд гүйцэтгэлийн аудитууд бүрэн хийгдсэн байна.

Орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитаар орон нутаг хичнээн өмч хөрөнгөтэй вэ, хэдэн хувь нь бүрэн ашиглагддаг вэ, хэдэн хувь нь хагас ашиглагддаг, үүнээс болж ашиглалтын зардал үргүй зарцуулж байгаа эсэх, бусдад ашиглуулж байгаа бол хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа зэрэг олон асуултад хариу өгсөн үр дүн бий болгох зорилго тавьсан.

Үүний дүнд орон нутгийн удирдлагад өмчийн талаарх бодлого төлөвлөлтийн шийдвэр гаргах түвшинд бодит мэдээлэл өгөх, аудитын байгууллагын зүгээс орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналтын чиг үүрэгт туслахад өөрийн зохих хувь нэмрээ оруулах, цаашид өмч хөрөнгийн ашиглалтыг үр дүнтэй байлгахад зохистой, оновчтой зөвлөмж өгөхөөр төлөвлөн ажилласан. Аудитын зорилгоо дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Хөрөнгийг хууль, тогтоомжийн дагуу үр ашигтай эзэмшиж, ашиглаж байгаа эсэх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн эсэх
- Орон нутгийн өмчийн хөрөнгийг хууль, тогтоомжийн үр ашигтай захиран зарцуулсан эсэх

Аудитад 14 сумын 63, аймгийн төвийн 10, нийт 73 төсөвт байгууллагыг хамруулсан нь аймгийн нийт төсөвт төрийн өмчит байгууллагын 36%-ийг эзэлж байна.

Аудитаар:

- Өмч хөрөнгө олж бэлтгэхдээ зохих зөвшөөрөл шийдвэрийг гаргуулдаггүй
- Үндсэн хөрөнгөө зориулалтын дагуу үр дүнтэй бүрэн ашигладаггүй
- Өмч хамгаалах байнгын зөвлөл ажилладаггүй
- Ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдээгүй
- Зарим хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хангалтгүй
- түрээсээр ашиглуулж байгаа үйл ажиллагаа үр ашиг муутай зэрэг зөрчлүүд нилээд илэрсэн.



Аудитын дүнг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн засаг дарга, өмчийн албаны даргад дэлгэрэнгүй танилцуулж, “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталж мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах тухай болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг үр ашигтай эзэмших, ашиглах, захиран зарцуулахад чиглэсэн арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх талаар зөвлөмж хүргүүлж, аудитаас хүлээгдэж байгаа үр дүнг тодорхой тайлбарлаж, танилцууллаа.

Орон нутгийн удирдлагаас энэ аудитын мөрөөр тодорхой арга хэмжээ авч, холбогдох шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх, үр дүнг эргэж танилцуулахаар тогтлоо.

Аудитаас хүлээгдэж байгаа үр дүнгийн талаар

- ✓ Нийт төсөвт байгууллагуудын 2016 оны санхүүгийн тайлан дахь ашиглагдахгүй байгаа болон ашиглалтын хугацаа дууссан өмч хөрөнгийн асуудал тодорхой хэмжээнд цэгцлэгдэж, хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалт, хариуцлага сайжирна.
- ✓ Санхүүгийн тайлангийн аудитаар илрэх алдаа зөрчлийн хэмжээ буурна.
- ✓ Өмч хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо сайжирч өмч эзэнгүйдэх, шамшигдах нөхцөл тодорхой хэмжээнд арилж, холбогдох эрх зүйн акт хэрэгжих болно.

Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийсэн аудитаар

1. Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааны зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөдөггүй, 2014-2016 онд тооцож төлөвлөсөн хэмжээ нь БНАТТХ-ийн 18.5-д заасан орлогын 85 хувиар тооцно гэснээс даруй 29.0-57.4 хувиар бага төлөвлөгдөж байгаа, Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, ойн менежмент төлөвлөгөөнд тусгаагүй газарт ойжуулалт хийсэн, ойжуулалтанд хуваарилсан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Сүүлийн 3 жилд хийсэн ойжуулалтын 65.2 хувь нь ургаагүй, шаардлага хангахгүй байгаа нь төсвийн 190.3 сая төгрөгийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, Ойг нөхөн сэргээх, үржүүлэх талаар хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүйгээс ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлбэл зохих ойжуулалтын **98.3** хувийг хийгээгүй, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ойжуулалтын **65.2** хувь нь шаардлага хангахгүй болсон, Ойн менежмент төлөвлөгөөг эрх бүхий байгуулага, албан тушаалтнаар хянуулж батлуулаагүй, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ аваагүй, гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан дүгнэлт хийж, үр дүн, үр нөлөөг тооцоогүй байгаа нь “Ойн менежментийн төлөвлөгөө ор нэр төдий зүйл болсон зэрэг



зөрчил дутагдал илэрсэн.

Аудитаас Орон нутагт ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүн, үр нөлөөг тооцох, ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай болжээ гэсэн дүгнэлтийг хийгээд байна.

Түүнчлэн ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нартай холбоотой 155.0 сая төгрөгийн ойжуулалтын нөхөн тарилт, хамгаалалт, хаяг, тэмдэгжүүлэлт хийлгэх, 44.9 сая төгрөгийн ногоон байгууламжинд мод тарих ажлыг гүйцэтгүүлж хүлээн авч нотлох баримтыг ирүүлэх албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлж, аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, үр дүн, үр нөлөөг тооцох, ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай 11 зөвлөмжийг аймгийн Засаг дарга, аймгийн БОАЖГ-т тус тус хүргүүлэн хэрэгжилтийг хангуулаад байна.

Энэхүү гүйцэтгэлийн аудитын тайланг Төрийн аудитын байгууллагын 2016 оны “Шилдэг тайлан”-д нэр дэвшүүлсэн юм. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 11 сарын 27-ны өдрийн 374 дүгээр тушаалаар баталсан “Оны шилдэг тайлан” шалгаруулах журмын дагуу “Ойжуулалт, ойн цэвэрлэгээнд зарцуулсан хөрөнгийн үр дүн” хийсэн энэ гүйцэтгэлийн аудитын тайланг аудитын стандарт, заавар журмын дагуу бүрдүүлж архивласан ажлын баримт, холбогдох материалын хамт 2016.12.01-нд УАГ-т хүргүүлээд байна.

Зургаа. Байгууллагын дотоод ажлын талаар

Орон нутгийн төсвийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийн талаар:

Абáèòîí äàñар тайланд îíä õëéñýí àóäèð, аудитîí ýâðàà цуглуулсан ôîîôîî, ñóäàèääà, ажиглалт, дүн дүгнэлтэд çí äýñëýí Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т заасны дагуу орлого нэмэгдүүлэх, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, мөн төсвийг төлөвлөн батлахад анхаарах асуудлын талаар дараах саналуудыг боловсруулан аймгийн ИТХ-д хүргүүлж ажиллалаа.

Үүнд хүргүүлсэн саналаас дурьдвал:

1. Төсвийн орлого нэмэгдүүлэх талаар:

Абáèòîí äàñðààñ орон нутгийн 2017 оны төсвийн орлогыг **252.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүргүүлсэн. **Орлого нэмэгдүүлэх саналыг** орлогын



бүрдүүлэлттэй холбоотой гаргасан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх замаар татварын бааз суурийг өргөжүүлэх, боломжит эх үүсвэрийг дайчлах нь зүйтэй гэсэн зарчмыг баримталж, зөвхөн 3-н төрлийн татварын хувьд орлого нэмэгдүүлэх саналын тооцоог хийж боломжит доод хэмжээгээр тооцож үзсэн болно.

2. Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар

- ❖ Орон нутгийн зарим төсөвт байгууллагуудын ажлын ачааллыг нягтруулан, тухайн байгууллагуудын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилах,
- ❖ орон нутгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, өмч хөрөнгөтэй холбоотой гарч байгаа зөрчил дутагдлыг таслан зогсоож, хөрөнгийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлж, ашиглалтгүй байгаа хөрөнгийг бүрэн ашиглахад зохион байгуулалтын арга хэмжээ авч төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлж ажилласнаар төсвийн нэмэлт үргүй зардал гарахаас сэргийлэх ,
- ❖ орон нутгийн өмчит компаний үйл ажиллагааг зохистой удирдан, ашигтай ажиллуулах, урсгал зардлыг оновчтой төлөвлөх, удирдлага менежментийг сайжруулан, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ноогдол ашгийг 2016 оны түвшинээс бууруулахгүй байх, цаашид нэмэгдүүлэхэд онцгой анхаарах
- ❖ Засаг даргын нөөцийн хөрөнгийн зарцуулалтанд бодитой хандахад анхаарах, нөгөө талаар журмын 2.3 дахь заалтыг хэрэгжүүлж, нөөцийг бий болгох ингэснээр урьдчилан төлөвлөх боломжгүй нөхцөл байдлын улмаас үүссэн хохирлыг бууруулах, арилгах асуудлуудыг шийдвэрлэхэд санхүүгийн эх үүсвэртэй байх боломж бүрдэх талаар санал хүргүүлээ.

3. Төсвийг төлөвлөн батлахад анхаарах асуудлын талаар

Монгол Улсын 2017 оны төсвийн онцлог байдал, ирэх онд улс орны эдийн засагт тохиож болзошгүй эдийн засгийн хямрал, тогтвортой бус байдлаас шалтгаалан төсвийн хумих бодлого баримтлаж байгаа үед төсвийн санхүүжилтийн эх үүсвэр буурах магадлал байж болохыг үгүйсгэх аргагүй, нөгөө талаас орон нутгийн төсвийн батлагдсан байдлыг харахад суурь орлогыг нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгийг бууруулах чиглэлтэй байгааг анхааран, 2017 оны орон нутгийн төсөв түүний дотор төлөвлөгөөнөөс давсан орлогыг хуваарилан батлахдаа эрсдэл нөхцөл байдлыг урьдчилан тооцож, Төсвийн тухай хуулинд заасан төсвийн үндсэн зарчим, хэмнэлтийн горимыг баримтлан өр авлага үүсгэхгүй байхад анхаарч, төсвийг үр ашигтайгаар зарцуулахаар оновчтой төлөвлөн батлах нь зүйтэй байна. Гэсэн саналуудыг хүргүүлж ажиллалаа.



Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

Тайлант онд манай байгууллагад хандан шалгалт хийлгэхээр 2 өргөдөл, 1 хүсэлт ирүүлснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын техник хэрэгслийн талаар:

Байгууллагын техник хэрэгсэлтэй холбоотой дуудлага урьд жилүүдээс харьцангуй ихсэж байна.

Энэ нь сүүлийн үеийн оффесийн программ хангамж, аудитын онлайн программууд дээр ажиллахад манайд ашиглагдаж байгаа суурин компьютерүүдийн үзүүлэлт хүрэхгүй гацах зэргээр техникийн шинэчлэлт хийх болсныг нэг талаар харуулж байна. Энэ байдал нь ажлын бүтээмжинд нөлөөлж байгаа бөгөөд мэдээлэл технологи хариуцсан шинжээч тухай бүрт нь өөрийн хүч бололцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

Үүний дүнд:

- Техник хэрэгслийн гэмтэлийг тухай бүрт нь шийдвэрлэж байсан нь ажлын бүтээмжийг алдагдуулаагүй.
- Принтерүүдээ цэнэглэж ашиглаж байгаа нь хэмжигдэхүйц хөрөнгө мөнгийг хэмнэж ажиллалаа.

Энэ байдалтай холбогдуулан нэн тэргүүнд солих шаардлагатай байгаа 3 суурин компьютер, онлайн сургалт, хуралд хэрэглэгдэх ажилтнуудын камер, чихэвчний асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлт, техник тоног төхөөрөмжийн бодит судалгааг гарган ЯАГ-ын Мэдээллийн технологи хариуцсан ахлах шинжээч Ш.Гантулгад хүргүүлж, уламжилж байсан.

Гэвч энэ асуудал тодорхой шийдэгдээгүй тул бид өөрсдийн хуримтлалын сангаас иж бүрэн компьютерүүд авахын оронд сүүлийн үеийн хүчин чадал бүхий үзүүлэлттэй 3-н процессор шинээр авч хуучин процессоруудыг сольж шинэчиллээ. Мөн ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах үүднээс цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинээр авч ашиглаж эхлээд байна.

Вэб сайт, хэвлэл мэдээлэлд өгсөн мэдээний талаар

Үндэсний Аудитын газрын www.audit.mn сайтад 27 мэдээлэл, 8 аудитын тайланг байршуулаад байна. Байгууллагын фэйсбүүк хаягаар үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаа. Санхүүгийн тайлангийн аудитаар 113 газарт, ГА болон НА-аар холбогдох албан тушаалтанд 32 хувь тайланг хэвлэж, ЯАГ-т 8 тайланг цаасаар хувиалан хүргүүлсэн байна.

Аудитын нээлт, хаалтын мэдээлэлд холбогдох 34 байгууллага, “Нягтлан бодогчийн мэргэжлийн ур чадвар, аудитын дүнд нөлөөлөх нь” хэлэлцүүлэгт 17



байгууллага, гэрээгээр ажилласан хувийн аудитын компани, шалгагдагч 4 байгууллага, шилэн дансны аудитаар 202, бусад аудитын явцад 4 нийт 256 байгууллагад мэдээлэл хийж, аудитын үйл ажиллагааг сурталчлан таниулж, зөвлөн тусалсан. Мөн орон нутгийн сонинд 4 мэдээ, телевизэд 3 мэдээлэл өгсөн байна.

Үүний дүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлж хэвшлээ.
- Аудитын тайлантай бүрэн эхээр нь нээлттэйгээр танилцах боломжтой болсон.
- Байгууллагын цахим хуудасыг идэвхитэй ажиллуулсаны дүнд орон нутгийн болон системийн хэмжээний 1600 гаран хэрэглэгчтэй болж эдгээр хэрэглэгчдэд аудитын газрын мэдээ, мэдээллийг тухай бүрт нь хүргэж байна.

2016 оны эхний 5 сард хийгдсэн аудитын үр дүнгийн талаар 2 шаттай хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эхний шатыг байгууллага дотроо зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн гол зорилго нь

Хүн бүр өөр өөрийн хийсэн ажилдаа үнэлэлт өгөх, эргэж харах, юуг орхигдуулсан, юунд анхаарах, бусдыг юунд анхааруулах, цаашид ямар арга хэмжээ авах, удирлагын зүгээс юуг анхаарах г.м асуудлын хүрээнд аудитын үе шат бүрд дүгнэлт хийсний дүнд аудитор, шинжээч бүр ажилдаа хянамгай, ул суурьтай, үндэслэл сайтай ханддаг болно.

Хэлэлцүүлгийн дүнгээс хүрэх үр дүн:

- Аудитор шинжээчдийн аудитын явцад гаргасан сул талууд бүрэн арилна.
- Зарим чухал асуудалд нэг мөр ойлголт өгч, мэдлэг нэмэгдэнэ.
- Аудитор, шинжээчдийн аудитын ажилд үр өгөөж бий болно.

Бий болсон үр дүн.

Аудитаас өгөгдсөн шийдвэр тбал: зарим зөвлөмж хэрэгжихэд оновчтой бус өөрөөр хэлбэл үр дүн, үр нөлөөт байдлыг авчрахааргүй болжээ, хүний нөөцийн асуудал дутагдалтай байсан, нотлох баримтаа сайн хянаагүй байснаас тайланд өөр утга орсон г. м алдаа, дутагдалтай зүйлүүдийг олж харан, харилцан ярилцаж аудитын баг бүр цаашид анхаарах асуудал, саналыг нэгтгэн сүүлийн хагас жилийн аудитад хэрэгжүүлж, ажиллахаар тогтож, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.

2 дахь шатны хэлэлцүүлгийг ММНБИ-ийн 20 жилийн ойтой холбогдуулан аймгийн МНБ-ийн дунд “**Нягтлан бодогчийн мэргэжлийн ур чадвар аудитын дүнд нөлөөлөх нь**” сэдвийн хүрээнд явууллаа.



Хүрэх үр дүн нь:

- Аудитын газар хийсэн ажлынхаа талаар мэдээлэл хүргэе.
- Аудитаас илрээд байгаа алдаа зөрчлийн дүнгийн 80 илүү хувийг бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил өөрөөр хэлбэл санхүүгийн ажилтан нягтлан бодогчтой холбоотой зөрчил илэрч байгааг мэргэшсэн түвшний нягтлангуудад сонсгох үүнийг шийдвэрлэх гарц, гаргалааг дэвшүүлэн тавих улмаар аймгийн төсвийн санхүү бүртгэлийн тогтолцоог сайжруулах, энэ нь аудитад үр дүн авчирна, үр өгөөж бий болно гэж үзсэн.
- Нийт нягтлан бодогч нарт хандан уриалга гаргахаар төлөвлөсөн.

Бий болсон үр дүн.

Оролцогчдын сэтгэл ханамж өндөр байлаа. **Өмнө санхүү бүртгэлтэй холбоотой хэлэлцүүлэг энэ хүрээнд явагдаж байгаагүй**

Хэлэлцүүлгээс гарсан шийдвэр нь :

Нийт санхүүгийн ажилтнуудад хандаж мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх тухай уриалга гаргалаа.

Нийт санхүүгийн ажилтнуудад зөвлөмж гаргая үүнийг ММНБИ-ийн салбар хариуцахаар мөн бүртгэл сайтай нэг байгууллага дээр үзүүлэх сургууль зохион байгуулъя гэсэн шийдэлд хүрсэн. Зөвлөмжид бүх нягтлангуудыг баримт эргэлтийн төлөвлөгөөтэй болгоё, өөрийгөө хянадаг болгоё зэрэг чухал санаанууд их гарсаныг тэмдэглэн дурьдаж байна. Аймгийн хэвлэлд уриалга гаргаж хэвлүүлэн, уриалгын мөрөөр тодорхой арга хэмжээ зохион байгуулан ажиллах талаар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст уриалгыг албан бичгээр хүргүүллээ.



Мэргэжлийн тасралтгүй сургалтын талаар:

Жил бүр МТС-ын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлдэг. Мэргэжлийн тасралтгүй сургалтаар ажилтнуудыг ажлын байранд нь тасралтгүй сургах зорилготой.

Сургалт хийхэд баримталдаг гол чиглэл нь:

- Сургалтын сэдвийг сонгохдоо ажиллагсдаас өөрсдөөс нь саналыг авдаг.
- Сургалтын 80%-ийг аудитор, шинжээч нар өөрсдөө бэлтгэн хийхээр тооцсон. Үүний тулд тодорхой мэдээлэл цуглуулах ёстой. Ингэснээр өөрийнх нь мэдлэг нэмэгдэх болно.
- Тухайн сургалтыг хөтлөн явуулах аудитор, шинжээч сургалтын тэр цагийг яаж үр дүнтэй заасан хичээлээ бусдад ойлгуулж хүргэхийн тулд өөрөө арга зүйгээ олох ёстой.
- Мөн аудитор, шинжээчдийн ярих ур чадвар бусдад өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгдэх болно.
- Сургалтын 20%-ийг мэргэжлийн хүнээр заалгах тбал: аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчээр шинэ гарсан хуулийн талаар, аймгийн Монгол банкны мэргэжилтнүүдээр мөнгөний бодлого, үнэ, инфляцийн талаар, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, өмч хөрөнгийн талаарх хичээлийг аймгийн орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр, хичээл орууллаа.

Энэ арга хэлбэр нь аудитор, шинжээчдийн мэдлэгт чухал гэж үзсэн.

Бий болсон үр дүн:

Мэргэжлийн тасралтгүй сургалтыг төлөвлөгөөний дагуу явуулж жилийн төлөвлөгөөт сургалтыг бүрэн зааж дуусгалаа. Зарим аудитор, шинжээч өөрсдийн хариуцсан сэдвийн хичээлийг сонирхолтой болгож хичээлийн дараа АХА тэмцээн хийж, түрүүлсэн хүмүүсээ урамшуулсан, зарим нь хичээлийн төгсгөлд audit.mn сайтад байгаа тест бөглүүлэх зэргээр сонирхолтой хэлбэрээр явуулсан төдийгүй аудитор шинжээчдийн сургалтанд оролцох идэвхи улам бүр нэмэгдэж, хичээл заах арга барил нь урьд урьдахаас илүү сайжирч, байсныг дурьдах нь зүйтэй байна. Тухайлбал: Хичээл заахын өмнө өмнөх долоо хоногт улс, орон нутаг, байгууллагад болсон үйл явдлын талаар болон аудитын ажилд хэрэглэгдэх шинэ шинэ мэдээллийг бусдадаа өгч хэвшлээ.

2016 оны 5 сард УАГ-ын Стратеги удирдлагын газрын менежерүүд ирж 2 өдөр стандартын сургалт зохион байгуулсан нь их үр дүнтэй сургалт болсон юм.

Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны талаар:

Үндэсний аудитын газрын харъяа Архангай аймгийн Аудитын газар нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг



сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах үүднээс 2016 оны 1 сарын 06-ны өдөр Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторoor батлуулан ажиллалаа. Нийт 11 зүйлийн 16 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл 100%ийн биелэлттэй байна.

Авилгын эсрэг соён гэгээрүүлэх, авилгатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын ХОМ хариуцсан ажилтан хуульд заасан хугацаанд Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, аудитор шинжээч нийт 11 хүний 2015 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн гаргуулан авч нэгтэн тайланг ҮАГ болон АТГ-т хугацаанд буюу 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлсэн. Мөн Архангай аймгийн Аудитын газарт жирэмсний амралттай байгаа ажилтны оронд түр ажлын байранд орсон ажилтнуудын "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг тухай бүр хүлээн авч ҮАГ-т холбогдох материалын хамт хүргүүлэн, АТГ-аас дүгнэлт гаргуулан ажилласан. 2015 онд 2 мэдүүлэг хянуулж, дүгнэлт гаргуулсаны дараа томилгоо хийгдсэн болно.

Ажилтнуудад Авлигатай тэмцэх хууль тогтоомж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар зөвлөгөө, мэдээллийг тухай бүр өгч, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд авч, нэгдсэн программд оруулж баталгаажуулан, тайлагнаж ажиллаа.

Төрийн аудитын байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах тухай журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар МУЕА-ын баталсан "Мэдээллийн ил тод байдлыг хангах журам" болон Шилэн дансны тухай хуулийн дагуу Архангай аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэсэн ажил, одоо хийгдэж байгаа аудитын талаарх мэдээллийг цахим хуудас болон цахим мэдээллийн дэлгэцэнд байршуулсан нь мэдээлэл олон нийтэд ил тод нээлттэй, тодорхой, ойлгомжтой байх нөхцлийг бүрдүүлсэн, олон нийтийн эрх ашигт нийцсэн зохимжтой ажил боллоо.


Мөн аудитын тайланг баталгаажуулснаас хойш нууцын зэрэглэлтэйгээс бусад тайланг тухай бүр цахим хуудаст тогтмол байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж байна. www.audit.mn цахим хуудаст цаг үеийн мэдээллийг тухай бүр шинэчилж байршуулсан зэрэгцээ *шалгаагдагч байгууллагуудаас шалгалтын явцад болон төгсгөлд ёс зүй, сонирхлын зөрчлөөс сэргийлэх*

талаар санал сэтгэгдэл, асуулга авч ажиллалаа. Энэ нь өмнөх жилүүдээс уламжлал болон тогтсон ажил бөгөөд энэ оны тухайд энэ санал асуулгын дүнд тухайн аудитор, шинжээчдийн талаар ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан, бусдад ямар нэг ёс зүйгүй сэтгэгдэл төрүүлсэн, харилцааны доголдол гаргасан тохиолдол байхгүй байна.

Энэ санал асуулгын дүнгээс аудитын ажиллагсдын мэргэжлийн ур чадвар, сургалтын хэрэгцээг харах мөн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн мөрдөж байгаа зэрэг олон үзүүлэлтийн үр дүнг харах талаас нь илүү ач холбогдол өгч ажилласан. Үүний дүнд нийт 40 санал асуулга авч дүн шинжилгээ хийлээ.


Архангай аймгийн Аудитын газрын үйл ажиллагаа, төсөвтэй холбоотой нийт 31 мэдээллийг тогтмол хугацаанд бүрэн тавьж ажиллалаа. Үүнээс гадна байгууллага дээр байрлуулсан мэдээллийн цахим самбарт ажиллагсдын дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл холбоо барих утас, гүйцэтгэсэн аудитын дүн, одоо хийгдэж байгаа аудитын зорилт төлөвлөгөө, багийн бүрэлдэхүүн, аудитын хуваарь зэрэг эн тэргүүний мэдээллүүдийг үйлчлүүлэгчдэд ойр байлгах үүднээс тогтмол мэдээлж хэвшлээ.

Байгууллагын мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинжээч, эрх бүхий албан тушаалтан Б.Азхүү “Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг”, шинжээч Г.Цог-Эрдэнэ “Авлигын эсрэг хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигаас урьдчилан сэргийлэх тухай” хуулиудын талаар аудитор, шинжээч нарт сургалт явууллаа. Сургалтаар олж авсан мэдлэгийн бататгах, шалгах зорилгоор “АХА” тэмцээн зохион байгууллаа.



Аймгийн аудитын газрын мэдээллийн самбар, нэгдсэн цахим хуудсанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 тогтоол, аймгийн аудитын газрын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг байршуулан иргэд танилцах, татан авч ашиглах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.

Мөн хийгдэж байгаа аудитын зорилт төлөвлөгөө, багийн бүрэлдэхүүн, аудитын хуваарь зэрэг эн тэргүүний мэдээллүүдийг үйлчлүүлэгчдэд ойр байлгах үүднээс нээлттэй цахим самбараар тогтмол мэдээлж хэвшлээ.



Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа дотоод сургалтаар ТАБ-ын ажилтны ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн талаар хичээлүүд заагдсан. Аудит бүрийн эхэнд нууцын баталгаа, ашиг сонирхлын зөрчилгүй тухай болон ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах тухай мэдэгдэлд аудитор, шинжээч нар гарын үсэг зурж баталгаа гаргаж хэвшсэн бөгөөд Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг зөрсөн зөрчил гараагүй болно. Шинээр орсон ажилтнуудад зориулан Төрийн аудитын байгууллагын ажилтны “Ёс зүйн дүрэм”-ийг судлуулан, танилцуулж байна.

Мөн Үндэсний Аудитын газрын ёс зүйн зөвлөлөөс гарсан зөвлөмж болон Төрийн Аудитын байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд мөрдүүлэх 6 зүйлийн ёс зүйн ерөнхий хэм хэмжээг “Мэдээллийн цаг”-аар нийт албан хаагчдад танилцуулан хамтдаа уншин, сонсож цаашид мөрдөж, анхааран хэвшил болгон ажиллахаар тогтлоо.

Мөн үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг нэгтгэн товхимол хэвлэн гаргаж, байгууллагын дотоод сүлжээнд файлаар татан танилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2016 онд аудитын явцад тохиолддог, эрсдэлтэй асуудлуудаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын хуульчдын холбоо, монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчтэй гэрээ байгуулан үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа.

Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлж байх хүрээнд, аудитын явцад АТГ-т мэдээлэх хэмжээний зөрчил илрээгүй байна. Харин татвараа нуусан байж болох аж ахуйн нэгжүүдийн орлогын судалгааг аймгийн Татварын хэлтэст шалгуулахаар хүргүүлсэн.



АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ҮАГ-аас санаачилсан “Авлигагүй хамт олон” аяны /2016-2017/ хүрээнд аймгийн Аудитын газрын Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг гаргаж хамт олноор хэлэлцэн баталсан. Манай байгууллага 2015 оны “Авлигагүй хамт олон” аяны нэгдүгээр шатанд амжилттай оролцож МУ-ын Ерөнхий аудиторроос өргөмжлөл гардан авсан бөгөөд 2016 оны 2-р шатны аянд амжилтаа бататгахыг хичээн ажиллалаа.

2016 оны төлөвлөгөөний онцлог нь **сар бүр нэг ажилтан нэг ажил** зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан. Аянд ажилтнууд маш идэвхитэй оролцож шинэлэг, үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсаныг хэлэхэд таатай байна.



Дарга, тэргүүлэх аудитор Д.Уламбаяр – Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд ойлгомжтой асуулт хариултын байдлаар бэлтгэн орон нутгийн “Архангай амьдрал” сонин хэвлүүлэн олон нийтэд танилцууллаа.

Ахлах аудитор Н.Алтантуяа – Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс байгууллагын өрөөнүүдийн хаалганд сэрэмжлүүлэг уриаг хэвлүүлэн наасан байна.



Шинжээч Х.Алтанчимэг – Хүмүүн цогцолбор 2-р сургуулийн ахлах ангиудын дунд “Авлигын эсрэг хууль, тогтоомж болон урьдчилан сэргийлэх, авлигын хор нөлөө” гэсэн сэдвээр сургалт, танилцуулга хийлээ. Сургалтанд 3 бүлгийн 94 сурагчид хамруулж, авлигын эсрэг мэдлэг мэдээллийг өглөө.




Шинжээч Г.Цог-Эрдэнэ – Байгууллагын ажилтнуудад авлигын эсрэг хууль, тогтоомжоор хичээл бэлтгэн, сургалтын дараа шалгалт авлаа.



Шинжээч Ж.Мөнгөншагай, Н.Энхчимэг нар - “Авлигын эсрэг хууль, тогтоомж болон авлигын хор нөлөө”-ний талаар брошур бэлтгэн байгууллага, иргэдэд тараасан байна. Мөн байгууллагын хамт олондоо “Бид авлигагүй хамт олон” гэсэн лого, хамт олны зургийг аяган дээр хэвлүүлэн дурсгал болгон өгөв.



Шинжээч П.Цэцэгдулам – Байгууллагын хамт олны дунд “Бид авлигагүй хамт олон” гэсэн сэдэвт шүлэг, зургийн уралдаан зохион байгууллаа. Уралдаанд нийт 5 баг оролцож шинжээч Ж.Мөнгөншагай, Х.Алтанчимэг нарын баг 1-р байр, Ахлах аудитор Н.Алтантуяа, шинжээч Б.Нямхүү нарын баг 2-р байрт шалгарлаа.



Шинжээч Б.Азхүү - Байгууллагын www.facebook.com/arkhangaiaudit хуудсаар Хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх зааварчилгаа, авлигаас урьдчилан сэргийлэх, хор нөлөөний талаарх танилцуулга, мэдээллийг 1600 иргэнд түгээж ажиллаа.



Цахим мэдээлэл болох SharePoint-ийг хэрхэн ашиглаж байгаа талаар:

Мэдээлэл технологи хариуцсан шинжээч цахим оффисын программ sharepoint-ыг ашиглах мэдлэг, арга зүйгээр сайн хангасны дүнд 2016 оны 1 сараас хойш манай ажилтнууд уг программыг маш идэвхитэй 100 % ашиглаж байна.

Байгууллагын хуудсанд үндсэн ажлын төлөвлөгөө, ирсэн бичиг, өргөдөл гомдол, хариутай бичгийн бүртгэлийн сан үүсгэж ажиллаж байна. Мөн ажилтнуудад хэрэгтэй дараах цэсийг нээж ажиллууллаа. Үүнд: цаг үеийн мэдээлэл, хийгдэж буй ажлын хяналт, үүрэг даалгаврын цэс, мэргэжлийн тасралтгүй сургалтын сан гэсэн цэс, байгууллагын ажилтнууд санал сэтгэгдэлээ чөлөөтэй солилцох нөхцлийг бүрдүүлсэн дотоод facebook-тэй болсноор хамт олон улам нээлттэйгээр санал сэтгэгдэлээ илэрхийлэх нөхцөл бүрдсэн.

Бий болсон үр дүн.

- ✓ Ажилтнуудын цагийг хэмнэсэн,
- ✓ цаасгүй технологийг дэмжсэн,
- ✓ ажлын бүтээмж дээшилсэн,
- ✓ Ажлын бус цагаар /гэрээсээ/ ажлаа хийх боломжийг бүрдүүлсэн үр дүнтэй ажил болж байна.

Бид өнөөгийн байдлаар энэ программ хангамжийг хамгийн эхэлж үйл ажиллагаандаа идэвхитэй ашиглаж байгаагаараа бусад орон нутгийн аудитын байгууллагуудаас давуу талтай гэж үзэж байгаа. Энэ давуу талаа улам хөгжүүлж мэдээллийн сангаа нэмэгдүүлэн хүн бүрийн 100%-ийн хэрэглээ болгож, үйл ажиллагааны зардлыг хэмжихүйц тодорхой хэмнэсэн, аудитад үр нөлөөгөө өгсөн түвшинд ашиглахаар зорьж байгаа.

Мөн байгууллагын дотоод мессенжер линкийг ашиглан сургалт явуулах, аудиттай холбоотой мэдээллийг УАГ-ын холбогдох аудитор, шинжээчдээс цаг алдалгүй асууж тодруулах, шатны шатны хяналтыг дэлгэцээр хянуулж засах, хийж буй ажлын талаар зөвлөгөө авах зэргээр үр дүнтэй ашиглаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:



- Байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийг Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартын дагуу хөтлөж байна. 2016 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- Албан хэрэг хөтлөлтийн мэдээ, архивт хүлээн авсан хадгаламжийн нэгжээр танилцуулбал: Ирсэн албан бичиг – 352, үүнээс хариутай бичиг – 18, шийдвэрлэсэн – 18, явсан албан бичиг – 372, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тушаал шийдвэр – 31, өргөдөл гомдол – 3 ирж бүрэн шийдвэрлэгдсэн байна.
- Байгууллагад ирсэн бичиг, өргөдөл гомдол, хариутай бичгийн бүртгэлийг цахим оффесийн программд оруулан хэзээ ирсэн, хэнд цохсон, утга г.м дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжийг бүрдүүлээ.
- Аудитын газрын ББНШКомисс хуралдаж байгууллагын архивт санхүүгийн аудитын – 58 баримт, гүйцэтгэлийн – 7 баримт, нийцлийн аудитын – 9 баримтыг хадгаламжийн нэгж болгосон байдлыг шалган байгууллагын архивт хүлээлгэн өглөө.
- Байгууллагын архивын өрөөний стандартад хяналт хийж, архивт хэрэгцээтэй байгаа баримт хадгалах кардонон хайрцаг, тавиурын хүрэлцээ хангамжийн талаар удирдлагад танилцуулж шийдүүлээ.

Бусад ажлын талаар:

Ажлын ачаалал ихтэйгээс ажилтнууд нэгдсэн журмаар сүүлийн 10 жил нарийн мэргэжлийн эмч нарын шинжилгээнд хамрагдаж чадаагүй байсан тул 2016 оны 06 дугаар сард байгууллагын бүх ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан шинжилгээнд хамруулсан, мөн Хангайн Манба дацан уламжлалт анагаах ухааны үүдэн эмнэлгийн эмч нарын оношилгоо үзлэгт хамрагдлаа.

Үзлэгийн дүнд ажилтнууд нарийн мэргэжлийн бүх шинжилгээнд хамрагдаж, зөвлөгөө авч, эмчилгээ хийлгэж, эрүүл мэндээ урьдчилан сэргийлсэн маш үр дүнтэй ажил боллоо.

Байгууллагын хамт олны эв нэгдэл, эрүүл мэнд, спортыг хөгжүүлэх зорилгоор 2016 онд **байгууллагын үндсэн ажлаас гадна хийгдэх ажлын төлөвлөгөөг** хамт олноос санал авч Тэргүүлэх аудиторoor батлуулан ажиллаж ирлээ.

Төсөв хөрөнгө хомс байгаа өнөөгийн нөхцөлд бид ажилчдын хуримтлалын санг бий болгож, сангаас байгууллагын өндөр настан И.Ням-Осорын эмчилгээний зардалд зориулан 120.0 мянган төгрөгийн, Тэргүүлэх аудиторт 200.0 мянган төгрөгийн, шинжээч Х.Алтанчимэгт 110.0 мянган төгрөгийн тусламжийг үзүүллээ.

Байгууллагынхаа ажилчдын дунд “Алтан намар” хүнсний ногооны өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгт байгууллагын ажилчид 3-н баг болон оролцож хүнсний ногоо болон жимсээр төрөл бүрийн салат, жүүс ундаа

бэлтгэн ажилчдын 1 өдрийн цайны цагаар бусдадаа танилцуулан шилдгийг шалгаруулан байр эзлүүллээ. 1-р байранд “Баялаг намрын дурсамж” баг орж тэргүүллээ.



2016 оны 4 дүгээр улиралд төлөвлөгөөт ажлуудаа бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллах үүднээс дараах ажлуудыг зохион байгуулж хийлээ. Үүнд:

- Бүтээлч сарын аяныг 2016.11.15-12.15-ныг хүртэлх хугацаанд зарлаж аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган батлууллаа.
- Тайлангийн хугацаанд хийгдсэн аудитаас гарсан бүх шийдвэрүүдийн хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулах, мэдээ тайлангаар ямар нэг үлдэгдэл тайлагнахгүй байхад анхаарч ажиллах үүднээс барагдаагүй төлбөрийн актны судалгааг гарган аймгийн ТЕЗ-д хүргүүлж, холбогдох арга хэмжээг авахуулах талаар аймгийн засаг даргын ажлын албатай хамтран ажиллаж, үр дүн гарч байна.
- 2017 оны аудитын сэдвийн захиалгыг өөрсдийн ажилчдаас журмын дагуу холбогдох маягтаар гаргуулан авч, аймгийн ИТХ-д албан бичиг хүргүүлж саналыг аваад байна.

Найм. Дүгнэлт, санал

Аудитын газрын хамт олон бид 2016 оны төлөвлөгөөт ажлаа 100% бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Цаашид манай байгууллага хамт олон, ажилчдын хувьд дараах асуудлыг шийдвэрлүүлэх саналыг гаргаж байна.

- **Нийгмийн хамгаалалын талаар**
 - Байгууллагаас гаргасан судалгаанаас үзэхэд бүх ажилчид 221.9 сая төгрөгийн цалингийн болон орон сууцны зээлтэй байдаг.



Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар байгууллагын дотоод журамд тусгасан хэдий ч нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх хэмжээний төсөв хөрөнгө батлагддаггүйгээс энэхүү заалт **огт** хэрэгжихгүй байна. Иймд ажилнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс байгууллагын төсөвт тодорхой хэмжээгээр хөрөнгө батладаг байх.

- Байгууллагын автомашины гүйлт, ашиглалтын хугацаа дууссан, техникийн аюулгүй байдал хангахгүй байгаагаас өөр байгууллагын машиныг гуйх, дайгдаж явах зэргээр аргацаан албан үүргээ гүйцэтгэж ирсэн. Одоо хөдөө сумдаар явах ажил маш их байгаа ч өөрийн автомашингүйн улмаас очиж ажиллаж чадахгүй нөхцөл байдал үүсч улам төвөгтэй болж байна. Энэ нөхцөл байдал нь аудитын ажлын чанар, үр дүнд нөлөөлөөд зогсохгүй аудитын байгууллагын хараат бус байдал алдагдахад хүргэж болзошгүй байна.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР